



# "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2023 оны хагас жилийн тайлан

---

"ЛэндМН ББСБ" ХК





# Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2023 оны  
эхний хагас жилийн тайлан

## • Бизнесийн үйл ажиллагаа

- 05 Үйл ажиллагааны хураангуй
- 06 Зээлийн үйл ажиллагаа
- 08 Компанийн онцлох үйл явдал
- 23 Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- 24 Хүний нөөц

## • Санхүү үйл ажиллагааны тайлан

- 28 Орлого үр дүнгийн тайлан
  - Санхүү байдлын тайлан
- 29 Мөнгөн гүйлгээний тайлан
  - Өмчийн өөрчлөлтийн тайлан
- 30 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

## • Эрсдэлийн удирдлага

- 33 Эрсдэлийн удирдлага

## • Компанийн засаглал


- 35 Компанийн засаглал
- 36 Хувьцаа эзэмшигчдийн хурал
- 37 Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаа
  - ТУЗ-ийн бүрэлдэхүүн
  - ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа
  - ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацааны мэдээлэл
  - ТУЗ-ийн хурлын тогтоол, төрөл болон бусад мэдээлэл
- 41 "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- 42 Дотоод аудит
- 44 Компанийн бүтэц, зохион байгуулалт
- 46 Удирдлагын баг
- 47 Хувьцааны мэдээлэл

# 1 Бизнесийн үйл ажиллагаа

- Үйл ажиллагааны хураангуй
- Зээлийн үйл ажиллагаа
- Компанийн онцлох үйл явдал
- Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- Хүний нөөц

## 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

2023 оны эхний хагас жилийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал





## ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2023 оны эхний хагас жилд нийт харилцагч нартаа 297.3 тэрбум төгрөгийн дүнтэй 1 сая зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна.

Түүнчлэн 2023 оны эхний хагас жилийн

зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2022 оны эхний хагас жилтэй харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 4.6%, олгосон зээлийн тоо 70.0%, зээлийн багц 95.2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


### Гэрээт харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянга/




### Бүртгэлтэй харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянга/




### Зээлийн багц

/Тэрбум төгрөг/




### Харилцагчид байршлаар

байршлаар




### Олгосон зээлийн дүн

/Тэрбум төгрөг/



### Олгосон зээлийн тоо

/Мянган зээл/




## Зээлийн багцын чанарын үзүүлэлт

2023 оны эхний хагас жилийн байдлаар зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 20.8%-иар буурч 4.7% хүрсэн ба зээлийн эрсдэлийн

сангийн нөөц 4.6 тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 110.7% хүргэж ажиллалаа.

### Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь




## ДИЖИТАЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ “ЛЭНДБОНД”-ЫН ӨГӨӨЖҮҮД ҮНЭТ ЦААСНЫ ДАНСАНД БАЙРШЛАА

2021 оны 12-р сарын 02-ны өдөр арилжаалсан “ЛЭНДБОНД Транч-1”-ын өгөөж 2023 оны 06-р сарын 02-ны өдөр, 2022 оны 03-р сарын 31-ний өдөр арилжаалсан “ЛЭНДБОНД Транч-2”-ын

өгөөж 2023 оны 04-р сарын 04-ний өдөр үнэт цаасны дансанд тус тус байршлаа.

#ДижиталХөрөнгөОруулалт #ЛэндБонд  
#СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав



## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2022 ОНЫ НОГДОЛ АШГАА ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ДАНСАНД БАЙРШУУЛЛАА

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 сарын 06-ны өдрийн 23/09 тогтоолоор нэгж хувьцаанд 1.75 төгрөг буюу Компанийн 2022 оны цэвэр ашгийн 23.4%, нийт 1,293,778,000 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсний дагуу 2023

оны 04 сарын 28-ны өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан нийт 6,873 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны дансанд байршууллаа.

#АсааАсуудлааШийд





## “ЛЭНДМН ББСБ” ХК НЬ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ШИНЭ “FLEXI” БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ТАНИЛЦУУЛЛАА

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Корпорейт Хотел энд Конвейшн Центрийн “Эвэнт” танхимд амжилттай зохион байгуулагдав.

COVID-19 цар тахлын улмаас “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал сүүлийн 3 жилийн хугацаанд цахимаар явагдаж байсан бол энэ удаад танхимаар зохион байгуулагдсан төдийгүй зах зээлд шинээр нэвтрүүлж буй “FLEXI” зээлийн бүтээгдэхүүнээ танилцуулж, нээлт хийснээрээ онцлог боллоо.

Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.36% нь оролцож дараах 6 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцах;
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;

4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох;
5. Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийг батлах;
6. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаярын зүгээс 2022 оны



үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн онцлох зүйл нь зээлийн багц өмнөх жилээс 2.1 дахин өсөж 71.1 тэрбум төгрөг, компанийн цэвэр ашиг 5.5 тэрбум төгрөгт хүрч, амжилттай ажилласан болохыг дурдлаа. Ийнхүү компанийн нэгж хувьцаанд 1.75 (нэг зууны далан тав) төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэж, 2022 оны цэвэр ашгийн 23.4 (хорин гурав аравны дөрөв) хувийг буюу 1,293,778,000 (нэг тэрбум хоёр зуун ерэн гурван сая долоон зуун далан найман мянга) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн

хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаа дахин мэдэгдсэн юм.

Хурлын үеэр Бизнес хөгжлийн газрын захирал Д.Баасандорж “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 онд хийгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйл ажиллагааны чиглэл, зах зээлд шинээр нэвтрүүлж буй уян хатан, онцгой нөхцөлтэй “FLEXI” зээлийн бүтээгдэхүүнээ танилцуулж, албан ёсоор АСААЖ буйгаа мэдэгдсэн нь хувьцаа эзэмшигч, харилцагчдадаа барьж буй гэнэтийн бэлэг болсон байна.





## “ЛЭНДМН ББСБ” ХК НЬ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫНХАА ХҮРЭЭНД “ХҮН БҮР БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ” НӨЛӨӨЛЛИЙН АЯНЫГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА

Цагдаагийн байгууллагаас хүрээлэн байгаа орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, байгаль хамгаалах ажилд иргэн бүр идэвх санаачилгатай оролцох соёлыг түгээх, бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, эх орноо хайрлан хамгаалдаг,

нийгмийн хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “ХҮН БҮР БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулсан билээ. Тус аяныг ЛэндМН дэмжин харилцагчдаа эх дэлхийгээ хайрлаж, хүн бүр байгаль хамгаалагч гэдгийг уриалан ажиллалаа.


## МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ НЭРЭМЖИТ САГСАН БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ЛЭНДМН-ИЙН ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ БАГ АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны нэрэмжит Шилжин явах цомын төлөөх “Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн” 2023 оны 05-р сарын 05-07-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдав.

Тус “Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн”-нд 32 ББСБ-ын 40

багийн нийт 400 гаруй тамирчид хурд, хүч, ухаанаа сорин өрсөлдөж шилдгүүдээ шалгарууллаа.

Тэмцээнийг амжилттай зохион байгуулсан МББСБХолбоо болон Net-capital Financial Group -ын хамт олондоо нийт тамирчид, багуудынхаа өмнөөс баяр хүргэе.





## “ЛЭНДМН ББСБ” ХК НЬ МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ НЭРЭМЖИТ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД МОД ТАРИЛАА

Бид нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтод ажлуудад нийгмийн хариуцлагынхаа хүрээнд идэвх чармайлттай оролцдог. Энэ ч утгаараа МББСБ Холбоо-ны нэрэмжит “Минж үржүүлэх, нутагшуулах төв”-д байрлах “Цэцэрлэгт хүрээлэн”-д 2023 оны 05-р

сарын 13-ны өдөр мод тарилаа. Энэхүү үйл ажиллагаанд МББСБХолбооны Удирдах зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Гишүүн байгууллагуудын удирдлага болон хамт олон оролцож 4 төрлийн 640 мод тарилаа.

#Хүн\_бүр\_байгаль\_хамгаалагч\_байцгаая  
#Ногоон\_Ирээдүйгээ\_АСАА



## “ЛЭНДМН ББСБ” ХК НЬ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙГАА ХАМТДАА МОД ТАРИЛАА

“Мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Санхүүгийн Зохицуулах Хороо-оос өрнүүлсэн санаачилга, уриалгыг дэмжин 2023 оны 05-р сарын 14-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах “Инчьеон мөрөөдлийн төгөл”-д мод тарилаа.

Энэхүү үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын Ипотекийн корпораци ОССК, Үнэт цаасны төрөлжсөн хадгаламжийн төв, Монголын үнэт цаасны клирингийн төв тэргүүтэй нийт 20 гаруй байгууллагын хамт олон оролцож 1100 гаруй мод тарьж нэрэмжит төглийг бий болголоо.

Нийслэлийн байгаль орчны газраас “Инчьеон Мөрөөдлийн төгөл”-д 2023 онд 100 га талбайд 15,000 мод тарихаар төлөвлөжээ.

#Хүн\_бүр\_байгаль\_хамгаалагч\_байцгаая  
#Ногоон\_Ирээдүйгээ\_АСАА







## “ЛЭНДМН ББСБ” ХК ТОГТВОРТОЙ ХАА-Г ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ХОРШООДОД ХӨНГӨЛӨЛТЭЙ ЗЭЭЛ ОЛГОНО

“ЛэндМН ББСБ” ХК болон “МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО” ТББ-ын хооронд ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг хоршоо, бичил, жижиг бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хангаж тогтвортой, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд МХААХҮХ-ны хоршооны гишүүдийн байгаль орчин, нийгэмд ээлтэй, ногоон төслүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Санамж бичигт “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр, “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” ТББ-ын ерөнхийлөгч Ц.Алтантуяа нар 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр гарын үсэг зурлаа.

Тус хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд “ЛэндМН ББСБ” ХК нь МХААХҮХ-ны гишүүн хоршоодын байгаль орчинд ээлтэй, тогтвортой төслүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох төслийг хэрэгжүүлэх юм.

ЛэндМН-ийн хувьд тогтвортой ХАА-г дэмжих бодлогын хүрээнд хийгдэж буй анхны ажил гэдгээрээ онцлог юм. Хоршоодод санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь Монгол улсад хоршоо бие даан хөгжих, хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх, ХАА-н ЖДҮ-г хөгжүүлэх ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих гэх мэт чухал ач холбогдолтой” юм.

## “ЛЭНДМН ББСБ” ХК 2022 ОНЫ “ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ”-ООР ШАЛГАРЛАА

“Ажил олгогчдын зөвлөгөөн 2023”-ыг МҮХАҮТ-д 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан бөгөөд “ЛэндМН ББСБ” ХК-ийг Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангаж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг үнэлэн 2022 оны “ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ”-оор шалгаруулав. Шагналыг Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Ариунаа “ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргалд албан ёсоор гардуулжээ.

“ЛэндМН ББСБ” ХК нь үйл ажиллагаагаа явуулж эхлээд 7 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд 2 тэрбум гаруй төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд төлж, нийт ажилтан албан хаагчдын цалин хөлсийг нэг өдөр ч хоцроолгүй олгож, нийгмийн даатгалын тайланг цаг хугацаанд нь тайлагнаж шимтгэл төлөлтийг үнэн зөв цаг хугацаанд тайлагнаж ирсэн.

Бидний хувьд 2022 онд ковид цар тахал, эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран нийт ажилтнуудын цалинг 10.4%-аар нэмэгдүүлж, эрүүл мэндийн хувийн даатгалын үйлчилгээнд ажилтнуудаа сайн дураар хамруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж, ажлын байрны уян хатан цагийн нөхцөлийг бүрдүүлэн, ажил амьдралын балансыг сайжруулах тал дээр анхаарч, нийт ажилтнуудынхаа хувийн хөгжил, мэдлэг боловсролыг сайжруулахтай холбоотойгоор удирдлагын “1 on 1 Mentorship” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, “Өглөөний цай” хөтөлбөрийг тогтмолжуулан ажилтнууддаа ээлтэй, хамтдаа өсөн дэвжих шинэ шинэ боломжуудыг эрэлхийлэн хүн төвтэйгөөр ажилладаг билээ.

Цаашдаа “ЛэндМН ББСБ” ХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг тогтмол хэрэгжүүлэн даатгуулагч ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахаар хичээнгүйлэн ажиллах болно.







## ЛЭНДИЙН АВТОМАШИНЫ ЗЭЭЛ ШИНЭЧЛЭГДЭЖ, "ЦЭМБЭГЭР АЯЛИЙЛДАА" УРАМШУУЛАЛТ АЯНЫГ ЗАРЛАЛАА

Аяны хүрээнд автомашины зээл авсан харилцагч нартаа “Доктор авто сүлжээ компаниар үйлчлүүлэх 100.000 төгрөгийн эрх” бэлэглэн ажиллалаа.

Зээлийн нөхцөл шинэчлэгдсэнээр ЛэндМН-ийн харилцагчдаас гадна автомашин авахыг хүссэн хүн бүр Эко автомашинаас гадна бусад төрлийн автомашинуудыг Лэндээрээ авах боломжтой болсон.

Таны асаах автомашинуудад бид доорх нөхцөлийг санал болгож байна.

1. Зээлийн хэмжээ: **300 сая төгрөг хүртэл**
2. Хугацаа: **60 хүртэл сар**
3. Урьдчилгаа: **20%**
4. АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ХҮҮ: **3.20%**  
Toyota Land Cruiser 300, Land Cruiser 200,

Land Cruiser Prado 150, Harrier, Crown, Alphard, Lexus LX570, Lexus RX450h, Lexus RX350

5. ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ХҮҮ: **2.99%**

Toyota Aqua, Prius-30, 40, 41, 50, Harrier, Sai, Crown, Alphard, Lexus RX450h, Lexus RX350

**Цэмбэгэр шинэ машинаа аваад, цэвэрхэн хоггүй, аз жаргалтай аялцгаая.**

Дэлгэрэнгүй мэдээллийг:

auto@lend.mn  
7707-0101

#Lendauto #Автомашины\_Зээл

## “ЛЭНДМН ББСБ” ХК НЬ АВТОМАРТ АВТО ХУДАЛДААНЫ ТӨВӨӨС ЗОХИОН БАЙГУУЛСАН “АВТО МАШИНТАЙ БОЛОХОД АМАРХАН” ӨДӨРЛӨГТ АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

2023 оны 05-р сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Автомашинтай болоход амархан өдөрлөг”-т LendMN аппликейшн дээр автомашины зээлийн эрх үүссэн бол газар дээр нь Автомашины зээлийн гэрээгээ байгуулаад автомашинтай болох боломжийг харилцагчдадаа бүрдүүлэн ажиллалаа.

Лэндийн автомашины зээлийг сонгож автомашинтай болсон эхний 10 худалдан авалтад 200,000₮-ийн бэлэг бэлэглэлээ.

#Lendauto  
#АвтомашинааАсаа





# САЙН УУ, ИРЭЭДҮЙ МИНЬ

МАРГААШИЙН МӨРӨӨДЛӨӨ  
БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД, ӨНӨӨДРӨӨС  
БЭЛДЭЦГЭЭ.

## 13-18 НАС

2023.05.28  
ТУСГААР ТОГТНОЛЫН ОРДОН,  
З ДАВХАР, БАГА ТАНХИМ



## “САЙН УУ, ИРЭЭДҮЙ МИНЬ” ЭВЕНТИЙН “ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ”-ЭЭР АМЖИЛТТАЙ АЖИЛЛАЛАА

ЛэндМН нь MENTOR HUB -тай хамтран хүүхдийн баярыг угтан ирээдүйн эзэд болсон 13-18 насны өсвөр насны хүүхдүүдэд мэргэжлээ зөв сонгох, санхүүгээ хэрхэн зөв удирдахад зориулсан “САЙН УУ, ИРЭЭДҮЙ МИНЬ” эвентийн “ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ”-ээр ажиллалаа.

Эвентийг зорин ирсэн хүүхдүүдэд Лэндийн ах, эгч нараас нь гарын бэлэг өгснөөс гадна, Lend Plus-Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг танилцуулан мэдээлэл хүргэж санхүүгийн мэдлэгт нь хувь нэмрээ оруулахыг зорин ажиллалаа.

Хамтран ажилласан бүхий л дэмжигч байгууллагууд болон тус эвентэд идэвхтэй оролцсон гэр бүл, эцэг, эхчүүд нийт хүүхдүүддээ баярлалаа.

Та бүхний ирээдүй үргэлж гэрэлтэж АСАЖ байх болтугай.

#ирээдүйгээАсаа

## МББСБХОЛБООНООС 10 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА “БИД САНХҮҮЧ ГЭР БҮЛ” СЭДЭВТ “ХҮҮХДИЙН ГАР ЗУРГИЙН УРАЛДААН”-ЫГ ХАМТРАН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАЛАА

“Бид санхүүч гэр бүл” сэдэвт хүүхдийн гар Зургийн уралдаанд ирүүлсэн нийт 116 бүтээлүүдээр “ЛэндМН ББСБ” ХК-ийн харилцагчийн үйлчилгээний төвд ҮЗЭСГЭЛЭН гаргаж 2023 оны 05-р сарын 30-ны өдөр шагнал гардуулах ёслолыг амжилттай зохион байгууллаа. Гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг мэргэжлийн зураач шүүгч уран сэтгэмж, зурах техник, бүтээлч байдлыг харгалзан үзэж 9 хүүхдийн бүтээлийг шилдгээр шалгаруулав. Шилдгээр шалгарсан болон уралдаанд оролцсон бүх хүүхдүүддээ

Лэндийн ах эгч нараас нь хүүхдийн баярын бэлэг гардуулж, хүүхдийн инээд бялхсан сайхан үйл ажиллагаа болж өнгөрлөө.

Авьяаслаг бяцхан зураачид маань бүтээлээрээ дамжуулан гэр бүлийн хадгаламж, санхүүгийн төлөвлөлт, ирээдүйн зорилгоо өөрсдийн уран сэтгэмж, өнгө будгийг хослуулан илэрхийлсэн нь эцэг эхчүүд болон зохион байгуулагчид бидний сэтгэлийг маш их хөдөлгөж байлаа.





## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ФИНТЕК ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АЛБАН ЁСООР БҮРТГЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу финтек зээл олгож буй байгууллагууд нь тухайн финтек зээлийн бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, бүртгүүлэх үүрэг хүлээгээд байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд тус журамд заасан шаардлагуудыг бүрэн

хангасан тул Санхүүгийн зохицуулах хороо нь 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр LendMN аппликейшныг холбогдох хууль, журмын шаардлагыг хангасан гэж дүгнэж, LendMN аппликейшнаар олгож буй финтек зээлийн бүтээгдэхүүнүүдийг албан ёсоор бүртгэжээ.



Танай компанийн “LendMN” аппликэйшнийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх хүсэлтийг Цахим зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн цахим хуралдаанаар хэлэлцэн холбогдох хууль, журмын шаардлагыг хангасан гэж дүгнэж, үйл ажиллагаа явуулах боломжтой финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэснийг үүгээр мэдэгдэж байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГЫН ТАВБИН  
ДАРГА



БИТГЭЛСҮРЭН

## КОМПАНИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ



### ЛэндМН нь санхүүгийн хүртээмжтэй байдлыг хүн бүрд хүргэх зорилгоор:

Технологийн дэвшлийг ашиглан Улаанбаатар хотод 1 салбартайгаар, харилцагчдадаа цахимаар зээлийн үйлчилгээг үзүүлэн Монгол улсын өнцөг булан бүрд хүрч үйлчилж байна.

Харилцагч бүрийн санхүүгийн асуудлыг шийдэхийн тулд зөвхөн тогтмол цалингийн орлоготой харилцагчдад зээл олгох бус тогтмол орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээл олгох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



2023 оны хагас жилд нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа 3 цаг зарцуулдаг гэж үзвэл бид цахимаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр 196.5 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 590 мянган цаг буюу 67 жилтэй тэнцэх хэмжээний хугацааг хэмнэх боломжийг олгожээ.



Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 17 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2023 оны эхний хагас жилийн турш нийт 167,813 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликэйшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар 54,138 харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 98.6%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэж ажилласан байна.



Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуулдаг. Бид 2.7 сая удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 106.5 тонн цаас хэмнэж 2,500 ширхэг мод аварчээ.

Барьцаагүй зээлийн үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдийн 207 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах үйлдлээс сэргийлж, барьцаа хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.



## ХҮНИЙ НӨӨЦ



- **Чөлөөт цаг, Аялал, Спорт:** Ажилтнуудынхаа эрүүл мэнд болон чөлөөт цаг сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 7 хоногт 1 удаа зааланд тоглох боломжийг бүрдүүлснээс гадна спортын олон төрөлт арга хэмжээ, зуны эко аялал, дотоод болон гаднын сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.
- **Өглөөний цай:** Бид ажилтнууддаа зориулан “Өглөөний цай” хөтөлбөрийг 6 дахь жилдээ үргэлжлүүлэн өглөө бүрийг хамтдаа аярилцаж, сонирхолтойгоор угтан ажлаа эхлүүлдэг.
- **Хамгийн чухал нь эрүүл мэнд:** “МИГ” даатгалын компанийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ажилтнуудаа тогтмол хамруулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хүссэн үедээ хамрагдах боломжийг олгож үргэлжлүүлэн ажиллаж байна.
- **Ажил амьдралын баланс:** Ажлын байрны уян хатан цагийн нөхцөлийг үргэлжлүүлэн, Лэндийн ажилтнуудын бүтээмжийг үндсэн зорилго болгон ажлын цагийн эхлэх хугацааг сонголттойгоор ажилласан нь сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн чухал үзүүлэлт боллоо.

### Манай хамт олон

Компанийн  
нийт ажилтнуудын тоо  
**90**

Үндсэн ажилтан  
**82**  
8  
Гэрээт болон цагийн ажилтан

Дундаж нас  
**31**



- **Management hours:** Ажилтнуудынхаа хувийн хөгжил, мэдлэг боловсролыг сайжруулахтай холбоотойгоор удирдлагын “Management hours” хөтөлбөрийг зохион байгууллаа.
- **Идэвхтэй бас оролцоотой:** Компанийн дотоод үйл ажиллагааг тогтмол сайжруулах, санал хүсэлтийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, цаашдын үйл ажиллагааны чиглэл, зорилгоо хамтдаа тодорхойлох “All staff meeting 2023” амжилттай зохион байгууллаа.
- **Ажиллах тав тухтай орчин:** ЛэндМН-ийн ажилтнуудыг тав тухтай орчинд ажиллахад анхаарч орчин үеийн шинэлэг дотоод засалтай оффисын байрыг шинэчиллээ. Мөн дартс, шатар болон ширээний теннис, шагайн харваа зэрэг чөлөөт цагаа зөв тухтай өнгөрөөх орчныг бүрдүүллээ.




# 2 Санхүү үйл ажиллагааны тайлан

- Орлого үр дүнгийн тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023 оны эхний хагас жилийн байдлаарх орлогын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 20.7 тэрбум төгрөгт хүрч 155.0%-иар, цэвэр ашиг 8.3 тэрбум төгрөгт хүрч 390.4%-иар тус тус нэмэгдсэн байна.

2023 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 93.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 102.2%-иар өссөн бол цэвэр зээлийн багц 1 дахин нэмэгдэж 82.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.





**Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/**

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2021Н1	2022Н1	2023Н1
Нийт орлого	6.4	8.1	20.7
Хүүгийн зардал	(1.7)	(1.8)	(4.1)
<b>Цэвэр орлого</b>	<b>4.7</b>	<b>6.3</b>	<b>16.6</b>
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(0.8)	(1.3)	(2.1)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	0.3	(0.8)	(1.2)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>4.2</b>	<b>4.2</b>	<b>13.3</b>
Удирдлагын болон ҮА-ны зардал	(2.1)	(2.3)	(2.9)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>2.1</b>	<b>1.9</b>	<b>10.4</b>
Татварын зардал	(0.3)	(0.2)	(2.1)
<b>Цэвэр ашиг</b>	<b>1.8</b>	<b>1.7</b>	<b>8.3</b>

**Санхүү байдлын тайлан /Аудитлагдаагүй/**

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021Н1	2022Н1	2023Н1
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	1.7	2.0	7.5
Зээлийн багц (цэвэр)	25.7	41.4	82.3
Бусад хөрөнгө	3.7	1.8	2.9
Үндсэн хөрөнгө	0.9	0.7	0.8
Биет бус хөрөнгө	0.2	0.4	0.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>32.2</b>	<b>46.4</b>	<b>93.8</b>

**Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/**

<b>Өр төлбөр</b>	<b>14.0</b>	<b>26.0</b>	<b>62.6</b>
Эх үүсвэр	12.5	20.5	52.2
Бусад өглөг	1.5	2.6	7.6
Хоёрдогч өглөг	-	2.8	2.8
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>18.2</b>	<b>20.4</b>	<b>31.2</b>
Хувьцаат капитал	9.1	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	9.1	11.9	22.7
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>32.2</b>	<b>46.4</b>	<b>93.8</b>

**Мөнгөн гүйлгээний тайлан /Аудитлагдаагүй/**

Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2021Н1	2022Н1	2023Н1
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1.6	(4.9)	(3.8)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.0)	(0.3)	(0.2)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(9.4)	2.3	5.6
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт</b>	<b>(7.8)</b>	<b>(2.9)</b>	<b>1.6</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9.5	4.9	5.9
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1.7</b>	<b>2.0</b>	<b>7.5</b>

**Өмчийн өөрчлөлтийн тайлан /Аудитлагдаагүй/**

Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
<b>2021.12.31-ний өдрийн байдлаар</b>	<b>10.8</b>	<b>(2.3)</b>	<b>0.1</b>	<b>11.3</b>	<b>19.8</b>
Тайлант үеийн цэвэр ашиг				1.7	
Ноогдол ашиг				(1.1)	
Халаасны хувьцаа					
<b>2022.06.30-ний өдрийн байдлаар</b>	<b>10.8</b>	<b>(2.3)</b>	<b>0.1</b>	<b>11.8</b>	<b>20.4</b>
Тайлант үеийн цэвэр ашиг				3.8	
Ноогдол ашиг					
Халаасны хувьцааны цэвэр худалдан авалт					
<b>2022.12.31-ний өдрөөр байдлаар</b>	<b>10.8</b>	<b>(2.3)</b>	<b>0.1</b>	<b>15.7</b>	<b>24.2</b>
Тайлант үеийн цэвэр ашиг				8.3	
Ноогдол ашиг				(1.3)	
Халаасны хувьцааны цэвэр худалдан авалт					
<b>2023.06.30-ний өдрийн байдлаар</b>	<b>10.8</b>	<b>(2.3)</b>	<b>0.1</b>	<b>22.7</b>	<b>31.2</b>



## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2023 оны эхний хагас жилийн байдлаар 2.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-н стандартын дагуу 4.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг

байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 110.7%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллалаа.

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021Н1	2022Н1	2023Н1
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	50.0%	41.5%	29.5%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	50.0%	47.3%	32.2%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	56.6%	43.9%	33.2%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	12.3%	8.7%	13.3%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	(14.9%)	(10.0%)	(39.9%)
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	36.8%	37.1%	78.5%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	6.4%	44.5%	30.5%



## 3

Эрсдэлийн  
удирдлага

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч болон харилцагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан харилцагч болоод бизнесийн орчинд нөлөөлж болох эрсдэлийг олон улсын аргачлалын дагуу хянаж Эрсдэлийн Удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ.

ЛэндМН нь Монгол улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийг үйл ажиллагаандаа нийцүүлснээр санхүүгийн үнэн зөв тайлагнал, үйл ажиллагааны үр дүнтэй байдал, урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд Үйл ажиллагааны эрсдэлийн гадаад болон дотоод орчны хүчин зүйлсийг улирал тутам шинэчлэн үнэлж алба нэгжүүдэд эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, холбогдох журам зааврын хэрэгжилтийг хангахын сацуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд тайлагнаж ажилласнаар Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх, засаглалыг тасралтгүй сайжруулах зорилго тавин ажиллаа.

Монгол улсын хэмжээнд шинээр хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомж түүнийг

даган гарсан Зохицуулагч байгууллагын тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа нийцүүлэн компанийн холбогдох дотоод журмуудад өөрчлөлт оруулан шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж эхэлсэн.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд Харилцагчийг таньж мэдэх, эрсдэлийг үнэлэх, хяналт тавих арга хэмжээг тогтмол үйл ажиллагаандаа хэрэгжүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаа.

Эрсдэл, хянан нийцүүлэлтийн нэгж нь компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, холбогдох дүрэм журамд нийцүүлэх ажлыг хариуцан ажилладаг бөгөөд комплаенсийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор Финтек зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл, харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тус тус үнэлж түүнийг бууруулах зөвлөмж хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба улмаар Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу холбогдох хууль тогтоомж, журмын шаардлагыг хангасан гэж дүгнэж, үйл ажиллагаа явуулах боломжтой Финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэгдсэн байна.



## 4

## Компанийн засаглал

- Компанийн засаглал
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаа
  - ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа
  - ТУЗ-ийн бүрэлдэхүүн
  - ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацааны мэдээлэл
  - ТУЗ-ийн хурлын тогтоол, төрөл болон бусад мэдээлэл
- “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- Дотоод аудит
- Компанийн бүтэц, зохион байгуулалт
- Удирдлагын баг
- Хувьцааны мэдээлэл

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: <b>“ЛэндМН ББСБ”</b>	МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: <b>I ангилал</b>
Хэлбэр: <b>Нээлттэй хувьцаат компани</b>	Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: <b>800,000,000</b>
Регистрийн дугаар: <b>5039754</b>	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: <b>6873</b>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: <b>Монголын хөрөнгийн бирж</b>	Үндсэн үйл ажиллагааны чиглэл: <b>Зээлийн үйл ажиллагаа</b>

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, түүнчлэн бусад холбогдох журам, засаглалын дүрэм, кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

ЛэндМН нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор байна.

ЛэндМН-ийн зүгээс Хөрөнгө оруулагч, Хувьцаа эзэмшигч болон Харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд

үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал, хагас жил, жилийн эцсийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримтлан ажиллаж, тухай бүр тайлан бэлтгэж олон нийтэд хүргээд байна.

Тодруулбал, 2022 оны жилийн эцсийн тайланг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр, 2023 оны I улирлын тайланг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажилласан болно.

2023 оны эхний хагас жилийн хугацаанд ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

### Хувьцаа эзэмшигчид

АНД Системс ХХК	600,000,000
Олон нийт	139,301,683
Халаасны хувьцаа	60,698,317

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРАЛ

ЛэндМН нь COVID-19 цар тахлын үед Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”)-ыг тасалдалгүй, мөн эрсдэлгүй зохион байгуулах үүднээс технологийн шийдэл ашиглан 2019, 2020, 2021 онуудад “цахим хэлбэр”-ээр амжилттай зохион байгуулсан билээ.

Харин 2022 оны ХЭЭХ-ыг ЛэндМН-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс танхимын хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсний дагуу 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Корпорейт Хотел энд Конвейшн Центрын “Эвэнт” танхимд амжилттай зохион байгуулав.

Тус ХЭЭХ-д саналын эрх бүхий хувьцааны 84.36% буюу 623,709,410 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна:

- Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайланг батлав;

- Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь улируулан сонгов;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлав;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тус тус баталсан байна.

ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчид хуралдаа идэвхтэй оролцож, ЛэндМН-ийн цаашдын хөгжил болоод үйл ажиллагааны талаар Удирдлагын багаас мэдээлэл авч, мөн өөрийн санал, хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд ЛэндМН-ийн ирээдүйд итгэж буйгаа цохон тэмдэглэж байв. ЛэндМН-ийн зүгээс өмнөх жилүүдэд ашигласан цахим санал хураалтын системийг энэ удаагийн ХЭЭХ-д ашигласан нь санал хураалтын дүнг түргэн шуурхай гаргах боломжийг бүрдүүлж, хурлын үр дүнтэй Хувьцаа эзэмшигчид богино хугацаанд танилцах боломжийг олгосноороо онцлог байлаа.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ЦААШИД “ТУЗ”), ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ нь ЛэндМН-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд ЛэндМН-ийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх захиралд компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийг бүрэлдэхүүнээр нь улируулан сонгоод байна. Ийнхүү ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүдийг улиран сонгогдсоноор ТУЗ-ийн 2022 оны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй

бөгөөд урьдын адил тогтмол үйл ажиллагаа явуулж, 2023 оны хагас жилд 2 удаа ээлжит хурал, 4 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 21 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1) Эрсдэлийн удирдлагын хороо, 2) Аудитын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

### ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (цаашид “ЗНДЦУХ”)	Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “ЭУХ”)	Аудитын хороо
<b>Бүрэлдэхүүн</b> С.Энх-Амгалан (Хорооны дарга) С.Боргил Д.Галхүү	Б.Итгэл (Хорооны дарга) С.Энх-Амгалан В.Баярсайхан Д.Галхүү Ц.Ууганбаяр Б.Хос-Эрдэнэ	Ж.Жаргалсүрэн (Хорооны дарга) О.Болдбаатар С.Боргил

ЗНДЦУХ нь 2023 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох болон ТУЗ-ийн 2023 оны төсвийн асуудлыг Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай хэлэлцэж, мөн Гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

ЭУХ нь 2023 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын хороо нь 2023 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон ЛэндМН-ийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, ЛэндМН-ийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.



### Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ")-ийн бүрэлдэхүүн



**О.БОЛДБААТАР**

ТУЗ-ийн дарга  
Аудитын хорооны гишүүн  
"АНД Глобал" Пти.Лтд-ийн ТУЗ-ийн гишүүн



**С.ЭНХ-АМГАЛАН**

ТУЗ-ийн гишүүн  
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга  
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн  
"Мэргэн инвестмент" Пти.Лтд-ийн ТУЗ-ийн гишүүн



**В.БАЯРСАЙХАН**

ТУЗ-ийн гишүүн  
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн  
"Томьёо Эд Тек" ХХК-ийн Үүсгэн байгуулагч / Захирал



**Б.Хос-Эрдэнэ**

ТУЗ-ийн гишүүн  
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн  
"АНД Глобал" Пти.Лтд-ийн Гүйцэтгэх захирал  
"АНД Системс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал



**Ц.Ууганбаяр**

ТУЗ-ийн гишүүн  
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн  
"АНД Глобал" Пти.Лтд-ийн Санхүү эрхэлсэн захирал  
"ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал



**Б.Итгэл**

ТУЗ-ийн гишүүн  
Эрсдэлийн удирдлагын хорооны дарга  
"АНД Глобал" Пти.Лтд-ийн Гадаад харилцаа хариуцсан Дэд захирал  
"АНД Системс" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



**Д.ГАЛХҮҮ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн  
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн



**С.БОРГИЛ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн  
Аудитын хорооны гишүүн  
"Сэргэлт Консалтинг групп"-ийн Гүйцэтгэх захирал



**Ж.ЖАРГАЛСҮРЭН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Аудитын хорооны дарга  
"Бейкер Тилли Далайван Аудит" ХХК-ийн Удирдлагын партнер / Гүйцэтгэх захирал

### ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацаа болон бусад мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2023 оны хагас жилийн ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	ЛэндМН-д хувьцаа эзэмшдэг эсэх
О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.0046%
С.Энх-Амгалан	83.4%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
В.Баярсайхан	88.8%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
Б.Итгэл	83.4%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.0001%
Б.Хос-Эрдэнэ	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.0023%
Ж.Жаргалсүрэн	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 6 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
С.Боргил	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 6 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	нийт хувьцааны 0.0009%
Д.Галхүү	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 2 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй

ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй

асуудлаар "дэмжсэн", "татгалзсан", эсхүл "түдгэлзсэн" санал гаргах боломжтой.

ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд ЛэндМН-ийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад шаардлагатай, ач холбогдол бүхий шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар, дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

## ТУЗ-ийн хурлын тогтоол, төрөл болон бусад мэдээлэл

Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
2023 оны 01 дүгээр сарын 25	100%	Эчнээ санал хураалт	4
2023 оны 02 дугаар сарын 06	100%	Ээлжит хурал	9
2023 оны 03 дугаар сарын 03	100%	Эчнээ санал хураалт	2
2023 оны 03 дугаар сарын 27	100%	Эчнээ санал хураалт	1
2023 оны 05 дугаар сарын 24	77.8%	Ээлжит хурал	3
2023 оны 06 дугаар сарын 27	100%	Эчнээ санал хураалт	2

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
5	6	3	4	3

2023 оны эхний хагас жилийн байдлаар Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс холбоотой талаас санхүүжилт

хүлээн авах, баталгаа гаргуулахтай холбоотой нийт 3 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

## “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ЛэндМН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа даган

мөрдөж, хэрэгжүүлэн ажилласан бөгөөд нэгдсэн үнэлгээний хүрээнд 2023 оны хагас жилийн байдлаар дараах үзүүлэлтэй байна.

Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%
ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4	66.6%
Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
Эрсдэлийн удирдлага	8	7	87.5%
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
Компанийн соёл	6	5	83.3%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	7	70%
<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>62</b>	<b>86.1%</b>

ЛэндМН нь “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг 86.1%-тай хэрэгжүүлэн ажиллаж, компанийн засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байна.

2023 оны үлдсэн хагаст ЛэндМН нь

өөрийн холбогдох баримт бичгүүдийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэчлэх, зохицуулалтуудыг Компанийн засаглалын кодекс”-тэй нийцүүлэхэд анхаарч ажиллах замаар өөрийн үнэлгээг тогтмол сайжруулахад анхаарах болно.



## ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЛэндМН нь Хамгаалалтын гурван бүс / Three lines of defence/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж,

тасралтгүй сайжруулан ажиллаж байна. Компанийн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог схемээр харуулбал:




Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн

баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнах, Гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.



## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН УДИРДЛАГЫН БАГ



**Ц.Ууганбаяр**  
“ЛэндМН ББСБ” ХК  
Гүйцэтгэх захирал

Банк, санхүүгийн салбарт 15 жил,  
“АНД Глобал” Пти.Лтд-д  
7 дахь жилдээ ажиллаж байна.



**К.Мадоно**  
“ЛэндМН ББСБ” ХК  
Ерөнхийлөгч

Банк, санхүүгийн салбарт 41 жил,  
“АНД Глобал” Пти.Лтд-д  
5 дахь жилдээ ажиллаж байна



**Д.Баасандорж**  
“ЛэндМН ББСБ” ХК  
Бизнес хөгжлийн газрын захирал

Банк, санхүүгийн салбарт 5 жил,  
“АНД Глобал” Пти.Лтд-д 3 дахь  
жилдээ ажиллаж байна.



**М.Түвшинжаргал**  
“ЛэндМН ББСБ” ХК  
Санхүү, үйл ажиллагааны  
газрын захирал

Банк, санхүүгийн салбарт 24 жил,  
“ЛэндМН ББСБ” ХК-д 7 дахь  
жилдээ ажиллаж байна.




**Г.Золжаргал**  
“ЛэндМН ББСБ” ХК  
Ерөнхий нягтлан бодогч

Банк, санхүүгийн салбарт 16 жил,  
“ЛэндМН ББСБ” ХК-д 3 дахь  
жилдээ ажиллаж байна.



## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Лэнд хувьцааны мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### 2023 онд :

2023 оны эхний хагас жилд Lend хувьцааны ханш оны эхнээс 35.2%-иар өсч нэгж хувьцаа 40.8 төгрөгт хүрч хаагдсан байна.

- Нийт арилжаалагдсан ширхэг - 12.0 сая ширхэг
- Нийт арилжаалагдсан үнийн дүн - 414.0 сая төгрөг



**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)

2023 оны хагас жилийн тайланг бэлтгэсэн:  
Маркетингийн албаны менежер Б.Батбилэг  
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр